

Тайлан хянасан:

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ**

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ  
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ

.....  
Э.АНХБАЯР

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН  
2026 1-р улирал**

№		Дэмжиж буй бодлогын баримт бичиг	Дэвшүүлж буй зорилт	Хүрэх үр дүн	Хүрсэн түвшин
1	“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2022-2026 ОНД УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН	1.3.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын нэр хаягийг Монгол бичиг, кирилл бичгээр бичих асуудлыг журамлаж, стандарт мөрдүүлэн нийгмийн соёлыг дээшлүүлнэ.	Монгол өв соёлоо хадгалсан уламжлалт монгол бичгийн хаягжилтын соёлыг нэвтрүүлнэ.	Төв байр, хүүхэд, уламжлалт эмчилгээний тасгийн гадна пасад, хаягжилтийг мөн, албан бичиг хэргийн хөтлөлтийг уламжлалт Монгол бичгээр хийнэ.	Төв байр, хүүхэд, уламжлалт эмчилгээний тасгийн гадна болон дотор хаягжилтыг Монгол болон кирилл бичгээр хаягжуулсан.  УХТЭ байгууллагын тамгыг Монгол бичгээр болгож бичиг хэрэгтээ ашиглаж эхэлсэн,

	ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА				Албан бичиг хэрэгт Мрнгол бичгээр давхар хөтлөж байна,
2		2.1.28. Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагсдыг төрөөс дэмжинэ.	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлнэ.	Мэргэжлийн цол зэрэгтэй, мэргэшсэн эмч, сувилагч, боловсон хүчний тоог нэмэгдүүлснээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжирна.  Цөмийн анагаах ухааны эмч нарыг гадаадын сургалтанд хамрагдаж мэдлэг чадвар дээшилснээр дэлхийн өндөр чадвартай мэргэжилтнүүдтэй тэнцэхүйц чадварлаг багтай болно.	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн албан бичгийн дагуу эрүүл мэндийн ажилтны төгсөлтийн дараах тасралтгүй сургалтын 2026 оны улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх гадаад сургалтын захиалгад Зүрх судас судлалын тасгийн 2 их эмч, 1 сувилагч, ангиографийн 1 техникчийг мэдээллийг явууллаа. Энэхүү захиалгаар их эмч Б.Батболд, Б.Отгонтуяа, сувилагч А.Соёлмаа, техникч М.Очир нар БНСУ-ын Улсан их сургуулийн эмнэлэгт ЕСМО аппаратын ашиглалт, хэрэглээг эмнэлзүйн практикт нэвтрүүлэх чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад II, III дугаар улиралд хамрагдана.  Монгол Улсын ЭМЯ-ны 2026.01.23-ны өдрийн 3/350, 3/329 тоот албан бичигт дурдсан Солонгосын олон улсын эрүүл мэндийн сан

					(KOFIN)-гийн “Ли Жун Үгийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр–2026”-ын хүрээнд сургалтад хамрагдах боломжтой Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер Г.Мөнхтулга, мэс заслын эмч С.Батжаргал, сургалт, гадаад харилцааны албаны мэргэжилтэн С.Сэндэр нарын мэдээллийг ЭМЯ-д илгээсэн.
3	2.2.1.Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.	Байгууллага хамт олонтой урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг идэвхитэй зохион байгуулна.	Монгол улсын засгийн газрын 224-р тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж эрт илрүүлэхийн ач холбогдлыг сурталчилан таниулснаар өвчлөлийг эрт шатанд илрүүлэн хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулан ажиллана.	Монгол улсын засгийн газрын 224-р тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж хүн амын дунд зонхилон дохиолдож байгаа өвчний талаар 1. Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх 2. “ХОДООДНЫ ХАВДРААС СЭРГИЙЛЬЕ” 3. Дэлхийн Глаукомын долоо хоног	

					<p>4. “БӨӨРНИЙ АРХАГ ӨВЧНИЙ МЕНЕЖМЕНТ, ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТ”</p> <p>5. “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих долоо хоног” нээлттэй өдөрлөгүүдийг ард иргэдэд сургалт, мэдээлэл өгөх байдлаар зохион байгуулсан</p> <p>Мөн ЭМЯ, НЭМҮТ болон УХТЭ-ийн Нийгмийн эрүүл мэнд тандалтын албаны мэргэжилтнүүдийн бэлтгэсэн 66 постер мэдээлэл, 20 видео шторк, рийл хэлбэрийн бичлэгнүүдийн эхний улиралд нийтлэн ажиллаж эхний улирлын байдлаар</p>
4	<p>2.2.10.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.</p>	<p>Гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан ажиллана.</p>	<p>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдлыг хангаснаар болзошгүй гамшгийн үед зохион байгуулалт сайтай байж тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэх боломж бүрдсэн байна.</p>	<p>Гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний дагуу тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэх үүднээс 1 сарын нөөц бүрдүүлэн ажиллаж байна.</p>	

5		<p>2.2.13. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношилгоо хийлгэж, эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай улсад ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.</p>	<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар (TQCSI Mongolia LLC) ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын баталгаажилтыг хийлгэх</p>	<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын баталгаажилттай эмнэлэг болсон байна.</p>	<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар (TQCSI Mongolia LLC) ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын баталгаажилтыг сунгуулахаар гэрээ байгуулсан. Санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байна.</p>
6		<p>2.2.15. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна. (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт)</p>	<p>Анагаахын шинжлэх ухааны шинэ дэвшилтэт эмчилгээг өөрийн оронд нутагшуулна.</p> <p>Зүрхний мэс заслыг хөгжүүлэх үндэс суурийг тавих</p>	<p>Эрхтэн шилжүүлэн суулгах багийн урт, богино хугацааны сургалтад хамруулан олон улсын түвшинд хүрсэн чадварлаг хүний нөөцтэй болсон байна.</p> <p>Зүрхний төвийн үйл ажиллагааг цогцоор нь хүргэнэ, хэм судлалын багийг өргөжүүлснээр төвлөрлийг сааруулж иргэдийн хүлээлтийг бууруулна.</p>	<p>ЭМС-ын 2025 оны А/446 тоот тушаалаар УХТЭ-ийн бүтэц, дүрмийг шинэчлэх баталсан бөгөөд үүний дагуу эмнэлгийн Зүрх судас судлалын тасгийг өргөжүүлж Зүрхний төв болгосон. Энэхүү төв нь Зрх судас судлалын тасаг, шигдээсийн тасаг, хэм судлалын хэсэг гэсэн бүтэц бүрэлдхүүнээр ажиллана. Ингэснээр зүрхний эмгэгийн оношилгоо, ялангуяа хэм судлалын тусламж</p>
7					

				<p>үйлчилгээ, интервенци эмчилгээний судсан дотуурхи аргууд нэмэгдэнэ. Цөмийн оношилгоо эмчилгээний төвийн СПЕКТ-КТ оношилгоог зүрхний булчингийн тэжээлийн байдлыг үнэлэхэд ашиглана. Эмчилгээний аргуудын хувьд судсан дотуур аргаар таславчийн ба хавхлагын гажгийг эмчлэх тоог нэмэгдүүлэх боломж гарч байна.</p> <p>МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй Эс эд эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулах төслийн элэг шилжүүлэн суулгах эмчилгээний дэд төслийн эхний багийн сургалтууд явагдаж дууссан бөгөөд эхний эмчилгээнүүд хийгдээд байна. Дараагийн мэс засал, элэг судлал, мэдээгүйжүүлэг, лхборатори, сувилахуйн багийн гадаад дотоод сургалтууд БНСУ-ын Самсунг эмнэлэг, УНТЭ, ХСҮТ-д тасралтгүй хийгдэж байна.</p>
--	--	--	--	--

					Мөн дээрхи төслийн бөөр шилжүүлэн суулгах дэд төслийн үйл ажиллагаа эхэлж, хамтын ажиллагааны ойлголцлыг БНСУ-ын Самсунг эмнэлэг, УНТЭ-тэй хийж, эхний багийн сургалтууд явагдаж байна.
8	2.2.17.Яаралтай түргэн тусламжийн үндэсний тогтолцоог шинэчлэн өөрчилж, онгоц, агаарын тээврийн үйлчилгээг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.	Яаралтай тусламжийн тасаг бүрэн тоноглогдсон автомашинтай болно.	Алслагдсан бүс орон нутгаас, цаг алдалгүй, аюулгүй, эрсдэлгүй тээвэрлэлт хийж үйлчлүүлэгчийн аюулгүй байдал ажлын чанар сайжирна.	Яаралтай тусламжийн тасаг бүрэн тоноглогдсон 2 автомашин авах техник тодорхойлолт бэлдсэн байна.	
9	2.2.26.Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	Олон улсын жишигт нийцсэн PACS болон RIS систем дагалдах мэргэжлийн мониторуудыг хангалттай нэмэгдүүлэх.	Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээний чанар ахисан түвшинд хүрнэ.	Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд эрүүл мэндийн сайдын тушаалаар, төвлөрсөн PACS системийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зураг хадгалах storage server-ийг ЭМЯ –ны санхүүжилтээр худалдан авалт хийж ашиглалтанд оруулснаар зураг хадгалах багтаамж нэмэгдэж үйл ажиллагаа сайжирсан.Алсын зайнаас цахим технологи ( <a href="http://www.pacs.mn">www.pacs.mn</a> ) ашиглан, орон	

					нутгийн эмнэлгүүдийн дүрс оношилгооны шинжилгээний (X-Ray, CT, MRI) мэдээлэл бүхий датаг хүлээн авч, нарийн мэргэжлийн дүрс оношилгооны эмч нар орон нутгийн дүрс оношилгооны эмч, техникч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шинжилгээний дүгнэлт бичих үйлчилгээ үзүүлсээр байна.
1 0	2.2.25.Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (телемедицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ. Алслагдсан аймаг, сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.	Телерадиологийн тусламж үйлчилгээний эрхзүйн орчныг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх	Алслагдсан аймаг, сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлснээр иргэдийн эдийн засгийн дарамт багасах цаашлаад цаг алдалгүй эрүүл мэндийн тусламж үзүүлж гарч болзошгүй эрүүл мэндийн хохирлоос урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.	Алсын зайн оношилгооны төв нь 2026 оны 1-р улиралд алслагдсан нийт 16 аймгийн нэгдсэн эмнэлгүүд болон 5 БОЭТ хамтран ажиллаж нийт дүгнэлт 797 дүгнэлт бичиж даатгалаас 110 дүгнэлтийн нэхэмжлэх илгээсэн байна.	

1 1		2.2.27. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	Стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ	Байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангаж урсгал засварыг хийж шугам хоолойг шинэчилснээр эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг тасалдал үүсгэхгүй явуулах боломж бүрдэнэ.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэгжилтийн хүрээнд урсгал засвар хийгдэж эхлээгүй
1 2		2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ	СПЭКТ оношилгооны олон тооны аргыг нэвтрүүлэх	99Тс Изотоп хиймийн холбогч худалдан авах үйл ажиллагааг хангах, шинжилгээг эмнэлзүйд бүрэн нэвтрүүлэн иргэдийн гадаад явах урсгалыг багасгана.	Олон улсын атомын энергийн агентлаг, МУ-ын Цөмийн энергийн агентлаг, УХТЭ-ийн хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд СПЭКТ-КТ тоног төхөөрөмжийн суурилуулалт, программ хангажийн тохргоо сургалт, эмч мэргэжилтний сургалт хийгдэж дууссан байна. Зүгшрүүлэлтийн үеийн эхний шинжилгээнүүд амжилттай хийгдсэн бөгөөд цаашдын тогтвортой үйл ажиллагаанд шаардлагатай нм хэрэгслийн худалдан авалтыг хууль, журмын дагуу хийж байна.

			18F- PSMA цацраг идэвхит эм үйлдвэрлэх технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Монгол улсын эмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, бүртгэлд бүртгүүлсэн байна.	
1 3			Дэвшилтэд технологид суурилсан хавдрын дүрс оношилгооны төрлийг нэмэгдүүлнэ	Тархины, хэвлийн, хөхний перфузи СТ оношилгооны үйлчлэх хүрээг тэлж шинжилгээний тоог нэмэгдүүлэх	
1 4			Робот мэс заслыг нэвтрүүлэх	Монгол улсад робот мэс заслыг нэвтрүүлж мэс засал хийж эхлэнэ.	
			Элэг шилжүүлэн суулгах хагалгааг УХТЭ-д нутагшуулах	Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний хүний нөөцийн сургалт, хамтын ажиллагаа, эм хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангагдаж, Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний дараах хяналтын чиглэлээр эмч мэргэжилтэн бэлтгэгдэж хагалгааг нутагшуулсан байна	Эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээг бүрэн хийж хагалгааны өрөөний бэлэн байдлыг бүрэн хангасан. Эрхтэн шилжүүлэн суулгасан өвчтөн хэвтэн эмчлүүлэх хэсэг зохион байгуулж халдвар хамгаалалтүүнийг хангасан урсгалыг зохион байгуулж агааржуулалт систем угсарч ажилбар боолт өрөө тасалгааг бүрэн тохижуулсан.2025 онд 5 тохиолдолд донорын элэг дурангийн аргаар тайрах мэс

				<p>засал хийж элэг шилжүүлэн суулгах мэс засал 5 тохиолдод хийж эмчилсэн.</p>
		<p>Бөөр шилжүүлэх суулгах хагалгааг УХТЭ-д шинээр нэвтрүүлэх</p>	<p>УНТЭ –ийн бөөр шилжүүлэн суулгах баг БНСУ-ын Samsung medical эмнэлэгтэй хамтран төслийг хэрэгжүүлж УХТЭ-т бөөр шилжүүлэн суулгах хагалгааг нутагшуулна.</p>	<p>МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй Эс эд эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулах төслийн Бөөр шилжүүлэн суулгах дэд төслийн үйл ажиллагаа эхэлж, хамтын ажиллагааны ойлголцлыг БНСУ-ын Самсунг эмнэлэг, УНТЭ-тэй хийж, эхний багийн сургалтууд явагдаж байна.</p> <p>Эхний мэс засал эмчилгээг хийх дэд бүтэц, тоног төхөөрөмжийн үнэлгээг Самсунг эмнэлэгтэй хамтран хийсэн. Дотоодын сургалтыг УНТЭ-т хийсэн бөгөөд хамтран ажиллах, мэс засал эмчилгээ, дараагийн хяналтыг хамтран хийх санамж байгуулсан байна. Бөөр шилжүүлэн суулгасны дараагийн хяналтын эмчийг бэлтгэсэн.</p>

1 5		4.6.8. Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх, санхүүгийн цахим үйлчилгээ хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийнэ.	Дижитал Монгол бодлогыг дэмжиж цахим бүртгэлийн нэгдсэн системд холбогдох.	Санхүү бүртгэлийн анхан шатны баримт бичгийг цахимжуулна. Үргүй зардал, илүү цагаар ажиллахыг багасгаж эдийн засгийн хэмнэлтийг бий болгоно.	
1 6		5.3.1.Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.	Цахим гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлнэ.	Цахим гарын үсгийг нэвтрүүлэн, Үйл ажиллагаа хэрэгжилт жигдэрсэн байна. Мэдээллийн аюулгүй байдал хангагдаж иргэдийн эмзэг мэдээллийг алдах эрсдэлгүй эмнэлэг болсон байна.	

	<p>“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ 17 ЗОРИЛГО”</p> <p>ЗОРИЛГО 2016-2030</p>	<p>3.1 2030 он гэхэд 100,000 амьд төрөлт тутамд эхийн эндэгдлийн түвшнийг 70-аас доош болгон бууруулах</p>	<p>Тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй байдлыг ханган ажиллаж, эхийн эндэгдэлгүй ажиллана</p>	<p>Бүсийн эмнэлэг, оношилгоо эмчилгээний төвүүдтэй хамтран ажиллаж арга зүйгээр хангаж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, мэдээллийг цаг тухайд авснаар эндэгдлийн тохиолдлыг зөв танин тодруулж тохиолдох эрсдэлээс сэргийлнэ.</p>	<p>Тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй байдлыг ханган ажиллаж, эхийн эндэгдэлгүй гаргахгүй байх тохиолдол эрсдэлийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>ЭМТҮЧАБ-ын албанаас Эмнэлзүй эмгэг судлалын бага хуралд Эрсдэлийн үнэлгээ, хөндлөнгийн дүгнэлт хийхдээ “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зөвлөлөөр” тохиолдлын хэлэлцүүлэг хийж, үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийж, сайжруулах үйл ажиллагааг чанар сайжруулах хэрэгсэл болох Паретогийн диаграммыг ашиглан гаргаж байна.</p> <p>Карте системийн хөгжүүлэлт хийгдэж байна. Өвчний түүхийн бүрдлийг бүрэн хэвлэх талаар ЭЗЗА, МТА-аас тасгуудад сургалт, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан</p>
--	--	--	--	--	---

	<p>МОНГОЛ УЛСЫГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН</p>	<p>7.3.4.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхыг сайжруулах</p>	<p>УХТЭ-ийн дэргэдэх ёс зүйн хорооны үйл ажиллагааг жигдрүүлж эмнэлгийн ажилтны ёс зүйн журмыг мөрдүүлэн ажиллана. Ажлын байран дахь ёс зүйн зөрчил мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулсан байна.</p>	
		<p>7.3.7.3 Кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.</p>	<p>Кибер аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах</p>	<p>Мэдээлэл аюулгүй байдлын стандарт ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлсэн байна.</p>	
		<p>8.1.1.2 Бүс, орон нутгийн төрийн үйлчилгээний ялгаатай байдлыг бууруулна.</p>	<p>Зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуутай хамтран ажиллах</p>	<p>Зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудыг сургалт арга зүйгээр хангаж, зөвлөн туслах арга хэмжээг өргөжүүлснээр иргэд орон нутагтаа оношилгоо эмчилгээнд хамрагдаж орон нутгаас ирэх урсгал буурсан байна.</p>	
<p>Эдийн засгийн өсөлтийг иргэддээ хүргэх 300 хоногийн ажлын төлөвлөгөө</p>	<p>1.2.1.Хүнс, эм, хүрээлэн буй орчны лавлагаа лабораторийн хяналт, хүчин чадал, аюулгүйн үзүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>2.1.1.Лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн, мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх</p>	<p>УХТЭ-ийн Нэгдсэн лабораторийн тасаг итгэмжлэлийн MNS ISO 15189:2024 стандартын гэрчилгээ авна.</p>	<p>Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 51/36 дугаар тушаалаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Нэгдсэн</p>	

				лабораторийн тасгийг MNS ISO 15189:2024 стандартын шаардлага хангасан гэж үзэн итгэмжлэл авсан
	1.10.1.Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.	Үр ашигтай тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, Үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг ЭМДЕГ-ын 12 тоот тушаалын дагуу хяналтыг нэмэгдүүлэх	ЭМДЕГ-тай тусламж үйлчилгээний гэрээлэлтийг бүрэн гүйцэтгэх. Гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналт сайжирна.	

ХЯНАСАН:

ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨЛӨВЛӨЛТ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

Д.ЦОГТ-ОЧИР

ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

Ц.ГАНЗОРИГ

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛЭЭ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

Б.ЖАВХАА

